



Б.ЭРДЭНЭ-ОЧИР
ХСИС-ийн
Шүүхийн шийдвэр
гүйцэтгэлийн
сургуулийн Шийдвэр
гүйцэтгэлийн
тэнхимийн ахлах
багш, хошууч

ХОРИХ ЯЛ ЭДЛЭГСДЭЭС ХОХИРОЛ НӨХӨН ТӨЛҮҮЛЭХ АЖИЛЛАГААНЫ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ, ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ЧИГ ХАНДЛАГА

Түлхүүр үгс: Ялтны хөдөлмөр, гэм хор, хохирол нөхөн төлөлт, эрх зүйн зохицуулалт

Нийгмийн харилцаан дахь хөдөлмөрийн нэгэн өвөрмөц хэлбэр бол ялтны хөдөлмөр юм. Ялтны хөдөлмөр нь Монгол Улсын хөдөлмөрийн хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай болон тэдгээрт нийцүүлэн гаргасан эрх зүйн актаар зохицуулагддаг. Тэдний хөдөлмөрийн үндсэн асуудлыг Засгийн газраас тогтоосон үйлдвэрийн чиглэлийн дагуу хорих анги, ялтан нэг бүрийг хөдөлмөрөөр хангах, тэдний хөдөлмөрийг шинжлэх ухааны үндэстэй зохион байгуулах, тохирсон цалин хөлс олгох, түүнчлэн хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны арга техникийн болон үйлдвэрлэлийн соёл, ариун цэврийн зэрэг олон

асуудлыг цогцоор хэрэгжүүлж ирсэн түүхтэй.

Шүүхийн шийтгэх тогтоолоор хорих ял эдэлж буй ялтнуудын 36 орчим хувь нь бусдад гэм хор учруулсны улмаас төлбөр төлөхөөр шүүхээр шийдвэрлэгдсэн байдаг.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай Монгол Улсын хуульд зааснаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь “Эрүүгийн хэргийн талаар гарсан шүүхийн шийтгэх тогтоолын хөрөнгө гаргуулах заалт, тэдгээрийн үндсэн дээр олгосон гүйцэтгэх” баримт бичгийг үндэслэн, гэмт хэргийн улмаас хохирсон нь шүүхээр тогтоогдсон иргэн хуулийн этгээдэд хууль тогтоомжид зааснаар төлбөр гаргуулахаар хуульд заасан ажиллагааг явуулна. Эдгээр ажиллагаанд:

- Төлбөр төлөгч буюу ялтны эд хөрөнгө байгаа талаар хуульд заасан журмаар мэдээлэл олж авах; түүний мөнгөн хадгаламж болон харилцах данснаас хасалт хийх, эд хөрөнгө болон биед үзлэг, нэгжлэг хийх, эд хөрөнгийг битүүмжлэх, албадан барьцаалах, хураах, худалдан борлуулах

- Ялтны бусдад байгаа өмч хөрөнгөөс хуульд заасан журмын дагуу төлбөр гаргуулах

- Хуульд заасан бусад үйл ажиллагаа тус тус багтана.

Гэмт хэргийн улмаас иргэд, байгууллагад учруулсан хохирлыг

барагдуулах, энэ төрлийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг хууль тогтоомжийн хүрээнд үр дүнтэй гүйцэтгэх үүднээс хорих ял эдэлж байгаа ялтны хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, ажлын байраар хангах улмаар хөдөлмөр хөлснөөс хохирогчийн хохирлыг аль болох түргэн шуурхай нөхөн төлөгдөх нөхцлийг бүрдүүлэх зорилгоор 2008-2012 онд “Ялтны гэм хорын хохирол барагдуулалтыг нэмэгдүүлж, төлбөр барагдуулалтанд хяналт тавин ажиллах хөтөлбөрийг”-ийг ШШГЕГ-ын даргын 2008 оны А/102 тоот тушаалаар батлан гаргаж, хэрэгжилтийг харьяа нэгжүүд болон ял эдэлж буй ялтнуудад сурталчлах ажлыг тухайн хорих ангиуд дээр зохион байгуулан ажиллаж байна.

Уг хөтөлбөрийг хэрэгжүүлснээр:

- Төлбөртэй ялтанг хугацааны өмнө тэнсэн суллахгүй байх

- Ялтныг ажлын байраар хангаж, нийгэмд зөв хүн болгон төлөвшүүлэх, тэдэнд мэргэжил олгох

- Ялтны ахуй хангамж, амьдрах орчин сайжирч, тодорхой орлоготой болгох

- Ялтны төлбөрийн мөнгийг хохирогчдод олгох ажиллагааг шуурхай олгох талаар бодит үр дүнг гаргахаар тодорхой асуудлыг дэвшүүлжээ.


Хорих ангид ял эдэлж байгаа ялтны хувьд удаан хугацаагаар хорих ялыг биечлэн эдэлдэг бөгөөд тэдгээр

нь хувьд ногдох хөрөнгө, орлогогүйгээс энэ төрлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэл хангалттай биелэдэггүй.

Хорих ял эдэлж буй ялтны биелүүлбэл зохих 14,1 тэрбум төгрөгийн 1749 гүйцэтгэх баримт бичгээс 0,7 тэрбум төгрөгийн 477 гүйцэтгэх баримт бичгийг бодитой биелүүлж, 13,4 тэрбум төгрөгийн 1212 гүйцэтгэх баримт бичгийн үлдэгдэлтэй, гүйцэтгэх баримт бичгийн 28,2 хувийг би?лүүлсэн байна. Энэ нь 2015 оны мөн үеэс 612 гүйцэтгэх баримт бичгээр буурсан үзүүлэлттэй байна.

2016 оны 10 сарын байдлаар ШШГЕГ-ын харьяа хорих анги, албадын үйлдвэрлэлд 569, туслах аж ахуйд 1800, аж ахуй нэгж байгууллагад гэрээгээр 356 ялтан тус тус улирлын шинж чанартай болон байнгын ажлын байраар хангагдан хөдөлмөр эрхэлж байна. 2662 ялтанд 290,8 сая /өссөн дүнгээр/ төгрөгийн цалин олгогдож, 50.1 сая төгрөгийг шүүхийн төлбөрт өөрийн цалингаас шилжүүлсэн байна.¹

ШШГЕГ-ын Мониторинг, статистик мэдээлэл сэтгүүл



Ялтнаас учруулсан хохирлыг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад хохирлын хэмжээ нь хадгаламж зээлийн хоршооны хэргийн хохирлыг оролцуулан тооцоход 52.8 тэрбум төгрөгөөр өсчээ./эх сурвалж/

Нийт ял шийтгүүлсэн ялтнаас учруулсан хохирлын 54.9 тэрбум төгрөгийн хохирол нь бусдын эд хөрөнгийг залилан мэхэлж авах гэмт хэрэг үйлдсэний улмаас учруулсан хохирол эзэлж байна. Өөрөөр хэлбэл нийт гэмт хэргийн улмаас учирсан хохирлын 93 хувийг залилангийн гэмт хэрэг, 7 хувийг бусад гэмт хэрэг эзэлж байна. Энэ нь залилангийн гэмт хэрэг сүүлийн үед ихээр үйлдэгдэх болсонтой шууд холбоотой.

Эрүүгийн байцаан шийтгэх тухай хуульд хохирогчийн эд хөрөнгийн эрх ашгийг хамгаалах ажиллагааг хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчид үүрэг болгоогүйгээс гэмт

этгээдийн эд хөрөнгийг эрэн сурвалжлах, олж тогтоох, хамгаалалтанд авах ажиллагаа хангалттай хийгддэггүй.

Зөвхөн гэмт хэрэг, түүнд холбогдогчийг илрүүлэх чиглэл рүү түлхүү анхаарснаас гэм буруутай этгээд нь шүүхийн шийдвэр гарахаас өмнөх шатанд эд хөрөнгөө нуун дарагдуулах, бусдад шилжүүлэх, худалдан борлуулах, улмаар шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх шатанд төлбөр төлөгчийн хувьд ногдох ямар нэгэн эд хөрөнгө, орлогогүй, төлбөрийн чадваргүй болсон байдаг.

Монгол Улсын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд “...хорих ангид ял эдэлж буй ялтны төлбөрийг түүнд ногдох эд хөрөнгөөс төлүүлж, үлдэгдэл төлбөрийг ялтны хөдөлмөрийн хөлснөөс сар бүр суутгал хийж

шийдвэр гүйцэтгэх албаны дансанд төвлөрүүлж байх”²-аар заасан.

Гэвч практикт гэмт хэрэг үйлдэж бусдад учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулахад ял эдлэгсдийн ихэнх хувь нь төлбөрийн чадваргүй, хөрөнгө орлогогүй, оршин суух тодорхой хаяггүй, ганц бие байдаг. Энэ нь шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд сөргөөр нөлөөлдөг.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага ялтныг ял эдлэх хугацаанд нь хөдөлмөрт татан оролцуулж, гэмт хэрэг үйлдэж бусдад учруулсан хохирлыг барагдуулах ажиллагааг тухайн хорих ангийн онцлогт нь тохируулан зохион байгуулж байгаа боловч ихэвчлэн хохирлын хэмжээ их байдгаас шалтгаалан хангалтгүй байдаг тул энэ төрлийн гүйцэтгэлийн ажиллагаанд төрийн зохицуулалт зайлшгүй шаардлагатай байгаа юм.

Тус байгууллага нь уламжлалт үйлдвэрлэлийг сэргээх, шинээр үйлдвэр байгуулах замаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа хорих ангиудад ял эдэлж байгаа ялтнуудыг барилга, барилгын материалын үйлдвэрлэл, шохой болон боржин чулуу олборлолт, мал аж ахуй, газар тариалан, мод, модон эдлэл, оёдол, уран дархан, бэлэг дурсгалын зүйл урлах гэх мэт ажлуудыг хийлгэх болсноор дээрх

чиглэлээр ажлын байраар хангасны улмаас хохирол барагдуулах ажиллагаанд тодорхой ахиц гарсан боловч хохирлын хэмжээ үлэмж их учир даацтай нөлөөлж чадахгүй байна.

Хуульд хорих ангид ял эдэлж буй ялтнаас гэмт хэрэг үйлдсэний улмаас бусдад учруулсан хохирлоо төлөөгүй тохиолдолд ялтныг хугацааны өмнө тэнсэн суллах саналыг шүүхэд оруулахгүй байх³ талаарх эрх зүйн зохицуулалтыг хуульчилсан нь өмнөх хуулиудад байгаагүй дэвшилттэй зохицуулалт болсон төдийгүй ялтнаас хохирол барагдуулахад онцгой хөшүүрэг болсон юм.

Уг эрх зүйн зохицуулалттай холбоотойгоор ялтнаас бусдад учруулсан хохирлоо нөхөн төлөх явдал өмнөх онуудаас нэмэгдэж байгаа хэдий боловч хүнд, онц хүнд гэмт хэрэг үйлдэж бусдын амь бие, эрүүл мэндэд хохирол учруулснаас үүссэн гэм хорын төлбөр биелэгдэхгүй удааширч, иргэд хохирсоор байгаад дүгнэлт хийж, энэ чиглэлээр онцгойлон анхаарал хандуулах зайлшгүй шаардлага бидний өмнө тулгараад байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай Монгол Улсын хуульд “гэмт хэрэг үйлдсэний улмаас учруулсан хохирлоо төлсөн” тохиолдолд

2002, 66.2)

³ (Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, 2002, 126.1)

² (Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль,

ялтанд тодорхой хэмжээний шагналын хоног олгох, ялыг хасах, ялтны ял эдэлж буй дэглэмийг бууруулах саналыг гаргаж шүүхээр шийдвэрлүүлж байхаар нэмэлт өөрчлөлт оруулах өөрөөр хэлбэл ялтныг аль болох хөдөлмөр хийх хохирлоо төлөх санаа сэдлийг бий болгох хөшүүрэг механизмыг бий болгох ялтнаас ялын хугацааг хүлээж зүгээр сууснаас өөрийн хүч чадлыг дайчлан ажиллаж хөдөлмөрлөснөөр өөрийн гэм бурууг хүч хөдөлмөрөөрөө цайруулах, нөгөө талаас ялтан өөрийн дансанд хуримтлал бий болгох эдийн засгийн сонирхол төрүүлэх түүгээр дамжуулж ялтныг хүмүүжүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгыг бүрэн утгаар нь хэрэгжүүлэх боломж бүрдэх юм.

Ялтны хөдөлмөрийн нөхцөл, цалин хөлс олголт зэргийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 120.1-121 дүгээр зүйл, мөн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2013 оны А/32 дугаар тушаалаар батлагдсан “Ялтны хөдөлмөрийн норм, хөлсний үнэлгээг тогтоох журам”-аар зохицуулж байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн (2002) 121 дүгээр зүйлийн 121.1-г “Ялтанд хийсэн хөдөлмөрийн нь тоо, чанарт тохирсон хөлс олгоно.” гэж заажээ.

121 дүгээр зүйлийн 121.3. дахь хэсэгт хорих анги ялтныг өөрийн

үйлдвэрлэл дээр ажиллуулсны болон энэ хуулийн 121.2.-т заасны дагуу шилжиж ирсэн цалин хөлснөөс бүх төрлийн төлбөр суутгал хийж үлдэх хэсгийг ялтны нэрийн дансанд төвлөрүүлнэ гэж заасан байна. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2013 оны А/32 дугаар тушаалаар батлагдсан “Ялтны хөдөлмөрийн норм, хөлсний үнэлгээг тогтоох журам”-ын 3.1-д зааснаар ялтныг дотоодын үйлдвэр болон иргэн, хуулийн этгээдтэй гэрээ байгуулан ажиллуулахдаа хүчин төгөлдөр буй хууль тогтоомжоор тогтоосон хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг баримтлан ажиллуулж байна. Ялтнууд илүү цагаар ажилласан бол цалин хөлснөөс тооцож нэмэгдэл хөлс олгохоор тусгажээ.

Ялтныг дотоодын үйлдвэр болон иргэн, хуулийн этгээдтэй гэрээ байгуулан ажиллуулахдаа хүчин төгөлдөр хууль тогтоомжоор тогтоосон хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг баримтлан цалин хөлс олгон ажиллуулж байгаа нь ялтныг албадан хөдөлмөр эрхлүүлж буй ойлголтод хамааруулж үзэхгүй байх боломжтой юм.

Гэсэн ч бодит байдал дээр ялтнуудын 36-59 хувь нь тухайн гүйцэтгэсэн ажилдаа ямар нэгэн хөлс аваагүй гэсэн судалгааны дүн гарсан байна. (сайн дурын үндсэн дээр болон заавал хийлгэх ажил аль аль нь багтсан) Хөлс авсан ялтнуудын

хувьд цахилгаан, ус, дулааны төлбөр, цэвэрлэгээ, замын зардал болон сургалт, түүнчлэн шүүхээс ногдуулсан хохирлын нөхөн төлбөр зэргийг суутгуулах нь түгээмэл байна. Нэмж тэмдэглэхэд, судалгаанд оролцогчдын хэн нь ч илүү цагийн хөлс аваагүй байна.⁴

Цаашид хорих ял эдлэгсдийн нийгэм, иргэдэд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх ажиллагааг эрчимжүүлэхэд дараах асуудлуудыг дэвшүүлж байна.

1. Гэмт хэргийн улмаас иргэнд учирсан хохирлын тодорхой хэсгийг буюу бүрэн төрөөс эргэн төлөгдөх нөхцлөөр барагдуулах эрх зүйн орчныг бүрдүүлэх;

2. Хохирогчдын хохирлыг нэн даруй цаг алдалгүй шийдвэрлэх үүднээс төрийн зүгээс “Хохирол барагдуулах төрийн сан” байгуулах, тухайн сангийн үйл ажиллагааг зохицуулах эрх зүйн орчинг бүрдүүлэх /Гэмт хэрэг зөрчилд оногдуулсан торгууль, шийтгэвэр, улсын орлогод оруулахаар хураагдсан эд хөрөнгийг борлуулсны үнэ зэргийг хохирол барагдуулах төрийн санд төвлөрүүлж, гэмт хэргийн улмаас хохирсон иргэдийн хохирлыг барагдуулахад зарцуулах/;

3. Ялтны ажлын байр шинээр бий болгох, тэднийг байнгын

ажилтай байлгаж, түүний ажлын хөлснөөс хохирлыг барагдуулах санд шилжүүлэх ялтны нэрийн дансанд хуримтлал бий болгох, ялтныг мэргэшүүлж суллагдахад нь бэлтгэж нийгэмшүүлэх ажлыг зөв зохион байгуулах;

4. Гэмт хэргийн улмаас учрах хохирлын эрсдлийн даатгалын тухай ойлголт, үүргийн эрх зүйн тухай ойлголтыг эрүүгийн эрх зүйд авч хэрэгжүүлэх нөхцөл боломжийг судлах;

5. Ялтны хөдөлмөрийг зохион байгуулж байсан уламжлалыг харгалзан, орчин үеийн менежментээр дараах салбаруудад ЗГ-н оролцоотой ажлын байрыг бий болгох.

⁴ Хүний эрхийн үндэсний комисс, Олон Улсын Хөдөлмөрийн байгууллага. (2016). Монгол Улс дахь ялтны хөдөлмөр эрхлэлтийн байдал: практик судалгаа.